

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

2025.01.10

1.1.1.Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгаврын цахим мэдээллийн сан бүрдүүлэн, хяналтад авч хяналт шинжилгээ үнэлгээ хийж тайлагнасан байдал:

- Хууль-8, Засгийн газрын тогтоол- 8, Эрүүл мэндийн сайдын 24 тушаалаар цахим сан үүсгэсэн.Эрүүл мэндийн салбарын албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэхээр “Хууль эрх зүйн” цахим Fgcebook групп -ээр хууль 5, ЭМС тушаал 10, мэдээ, мэдээлэл 11, видео бичлэг. 5 удаа тус тус байршуулж мэдээлэл хүргэсэн.Сум, өрхийн эрүүл мэндийн байгууллагууд хууль тогтоомж, тогтоол шийдвэрүүдээр цаим сан бүрдүүлж, баяжилт хийх арга зүйгээр хангаж ажилласан.

- Мөн “Хууль, эрх зүйн” цахим сургалт, мэдээллийн цагаар 14 хоног бүрийн Баасан гарагийн 15:00 цагт цахимаар сургалт, мэдээлэл хүргэж үйл ажиллагаа тогтмолжсон.2024 онд НЭМТҮ тухай хууль, ТАХ-ийн ёс зүйн тухай хууль, Хөдөлмөрийн гэрээ, Хувийн хэрэг хөтлөлт, ХАБ аюулгүй ажиллагааны зааварчилга,Төрийн болон байгууллагын нууцын тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, ЭМС-ын 2024 оны А/22 тушаал Ахмад настанд үзүүлэх тусламж үйлчилгээ, Санхүүгийн эрх зүйн шинэчлэлт, төрийн албан хаагчийн хувцаслалт, ЭМЯ-наас ирүүлсэн албан бичгийн дагуу хөдөлмөрийн дотоод журамд тусган хэрэгжүүлэх заалтын талаар, Төрийн нууц, Жендэр эрх тэгш байдал,Нийгмийн дзаатгалын багц хууль, Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хууль,, Ёс зүйн чиглэлээр баримтлах хууль эрх зүйн зэрэг 13 сэдвээр цахим сургалт, мэдээлэл хийхэд 133 байгууллагын 732 албан хаагч хамрагдсан.

- Эрүүл мэндийн сайдын 2023 оны 01 дүгээр “Эрүүл мэндийн тусламж чанар үйлчилгээний хүртээжийг нэмэгдүүлэх, ажилтнуудын сахилга хариуцлагыг сайжруулах тухай” албан даалгаврын хэрэгжилтийн тайлан ЭМГ-31 заалт, БОЭТ, Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, сум, өрх эрүүл мэндийн төвүүд-51 заалт бүхий хүснэгтээр нэгтгэж, тоон болон бичмэл хэлбэрээр тайланг Эрүүл мэндийн яаманд 4 удаа хугацаанд нь тайлагнасан. Жилийн эцсийн байдлаар хэрэгжилт 96,3 хувьтай.

- Эрүүл мэндийн тухай хууль”, “Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын тухай хууль”, “Эрүүл мэндийн даатгалын тухай хууль”-ийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, мэргэжил арга зүйгээр хангаж,БОЭТ, Хужирт, Бат-Өлзий Баянгол, Өлзийт, Төгрөг, Хайрхандулаан, ЗБУ, Уянсэтгэл, Энэрэл Хархорин ӨЭМТ сум, өрхийн төвүүдийн “Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын тухай хууль”, “Эрүүл мэндийн даатгалын тухай хууль”-ийн холбогдох заалтын хэрэгжилтэд үнэлгээ хийж, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан.

- Эрүүл мэндийн газар нь Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнөөр 28 хууль, бодлогын баримт бичиг-УИХ тогтоол -2, Засгийн газрын тогтоол-10. Бусад холбогдох байгууллагын шийдвэр-4,стандар-2, ЭМС-ын 2023-2024 оны 32 тушаал,

ЭМГ- даргын тушаал-1, аймгийн ИТХ-ын тогтоол-1 жагсаал гаргаж, 100ш хэвлэж, 100 албан хаагчдад хүргүүлсэн.

“1.1.2.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын шийдвэрийг тайлагнасан байдал:

-Хууль тогтоомж шийдвэрийн хэрэгжилтийн тайланг /Эрт илрүүлэгийн үзлэг, бэлгийн зам, сүрьеэгийн талаар, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дэмжлэг туслалцаа үзүүлэх, иргэдийн боловсрол, Монгол бичиг, шүдний эрүүл мэнд зэрэг 8 заалтаар сар бүр гаргаж, нийт 12 удаа аймгийн нийгмийн бодлогын хэлтэст хугацаанд нь хүргүүлсэн.

3.4.аймгийн Засаг дарга, түүний Тамгын газар, Төрийн албаны салбар зөвлөлөөс өгсөн хугацаатай үүрэг даалгавар, мэдээ тайлангийн ирц,чанар,өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаарх үнэлгээ:

- 2024 оны жилийн эцсийн байдлаар иргэдээс 55 өргөдөл, бүртгэгдэж, хуулийн хугацаанд шийдвэрлэн, иргэдэд албан бичгээр,цахимаар, утсаар хариуг хүргүүлж ажилласан. Хугацаа хоцорч шийдвэрлэсэн өргөдөл, гомдол гараагүй.

Өргөдөл, гомдолыг ирүүлсэн хэлбэрээр авч үзэхэд: бичгээр 42, биечлэн-1, цахимаар-4, утсаар-8 тус тус ирүүлсэн. Нийт 55 өргөдөл, гомдолд, хүсэлт 29 буюу 52,7 хувь, гомдол 25 буюу 45.4 хувь, санал 1 буюу 1,8 хувийг тус тус эзэлж байна.

Агуулгаар нь авч үзэхэд: Ажилд орох, чөлөөлүүлэх хүсэлт 11, гомдол-25 ирүүлсэн, үүнд, /эмнэлгийн тусламж үйлчилгээний талаар-13, харилцаа хандлага, ёс зүйн талаар-4, эмийн сангийн үйл ажиллагаатай холбоотой-2, рашаан сувиллын үйл ажиллагаатай холбоотой-3, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн талаар-3 гомдол тус тус бүртгэгдсэнийг тус тус шийдвэрлэж, иргэнд албан бичгээр болон утсаар хариуг хүргүүлж ажилласан.

Засгийн газрын Олон нийттэй харилцах 1111 утсаар-6, ЭМЯ-2, аймгийн нэг цэгийн үйлчилгээний 70321111 утсаар-8, эрүүл мэндийн газрын өргөдөл гомдол хүлээн авах утсаар-5 иргэн гомдол ирүүлсэн.Өргөдөл, гомдлын мэдээг улирал бүр гаргаж, аймгийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтэст нийт 4 удаа хугацаанд нь хүргүүлж байна.

Үр дүн: Урьд оны мөн үетэй харьцуулахад өргөдөлд гомдлын эзлэх хувь 3,7-оор буурсан.

ТАЙЛАН БИЧСЭН.

УДИРДЛАГА, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ХУУЛЬ,ЭРХ
ЗҮЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Ж.БОЛЗОЛ